

VIII АНГИЙН “НИЙГЭМ СУДЛАЛ” ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

2024.05.31

Сурагчийн нэр:

Хугацаа: 80 минут

Хувилбар А

1. Анхдагч бүлэг аль нь вэ? 2 оноо
А. Гэр бүл Б. Сургууль В. Дугуйлан Г. Эмнэлэг
2. Нийгмийн бүлгийг хэд ангилдаг вэ?. 2 оноо
А. 3 Б. 4 В. 5 Г. 2
3. Зөрчилдөөнийг цар хүрээгээр нь хэрхэн ангилдаг вэ? 2 оноо
А. Ил болон далд Б. Ширүүн болон алгуур В. Богино болон урт Г. Макро болон микро
4. Зөрчилдөөнийг шийдвэрлэх олон янзын хандлага бий. Тэдгээрийн нэг болох Томас Киллманы зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагад хамааралгүйг олно уу. 2 оноо
А. Зайлсхийх Б. Буулт хийх В. Хамтран ажиллах Г. Асуудлаас бултах
5. Өөрийн хүсэл эрмэлзэлээр үнэ хөлсгүйгээр орон нутаг, нийгмийнхээ төлөө хийж байгаа үйл ажиллагааг гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. 2 оноо
А. Ажил хөдөлмөр Б. Олон нийтийн ажил В. Сайн дурын үйл ажиллагаа Г. Арга хэмжээ
6. Зөрчилдөөнийг шалтгаанаас нь хамааруулан 3 ангилдаг. Илүүцийг олно уу? 2 оноо
А. Материаллаг Б. Оюуны В. Нийгмийн Г. Аюулгүй байдлын
7. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагын загварыг хэн боловсруулсан бэ? 2 оноо
А. А. Линколын Б. Д. Истон В. К. Томас, Р. Киллман Г. Э. Дюркгейм
8. Хувь хүний соёлын бүтцийн орхигдсон ойлголтыг зөв дугуйлаарай. 2 оноо



А. Яриа Б. Бичиг В. Үсэг Г. Бэлгэдэл

9. Аль хариулт зөв бэ? 2 оноо

А. Соёл бол нэг талаас хувь хүнийг хүмүүжүүлэх үйл ажиллагаа, нөгөө талаас хувь хүний идэвхтэй, бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон үнэт зүйлсийн тогтолцоо юм.

Б. Соёл бол хамтын амьдрал, үйл ажиллагааны чухал хэрэгсэл мөн.

В. Хариулт бүгд зөв.

10. Соёл нь биет болон биет бус хоёр хэлбэртэй. Биет соёлд хамаарахыг олоорой. 2 оноо

А. Баяр наадам Б. Урлаг В. Домог үлгэр Г. Хөшөө дурсгал

11. Соёлын өөрчлөлтөд нөлөөлөхгүй хүчин зүйлийг олоорой. 2 оноо

А. Байгаль орчин Б. Нээлт, бүтээл В. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилт Г. Нийгмийн харилцаа

12. Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг соёл судлалд юу гэж нэрлэдэг вэ? 2 оноо

А. Соёлын нэвчилт Б. Соёлын үнэт зүйл В. Соёлын бүтэц Г. Соёлын хожимдол

13. Хүний оюуны болон биеийн хүчний чадавх аль үйлдвэрлэлийн нөөцөд хамаарах вэ?

2 оноо

А. Газар Б. Капитал В. Ур чадвар Г. Хөдөлмөр

14. Оюуны соёлын жишээнд аль хамаарахгүй вэ? 2 оноо

А. Уртын дуу Б. Үлгэр домог В. Дуу хөгжим Г. Хөшөө дурсгал

15. Өрхийн тодорхой хугацааны орлого, зарлагын төлөвлөгөөг.....гэнэ. Цэгийн оронд нөхнө үү? 2 оноо

А. Хуримтлал Б. Өрхийн төсөв В. Зарлага Г. Төсөв

16. Өрх гэр олсон орлогоо хэрэглээ болгон хувиргах үйл явцыг.....гэнэ. 2 оноо

А. Орлого Б. Хуримтлал В. Зарлага

17. Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлд тогтоно. Цэгийн оронд тохирохыг олно уу. 2 оноо

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

18. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ. Зөв хариулт аль нь вэ? 2 оноо

А. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Үнэ

19 . Тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, түүнийгээ арвижуулах үйл ажиллагааг гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу. 2 оноо

A. Орон нутгийн төсөв Б. Зах зээл В. Үйлдвэрлэл Г. Бизнес

20. Үйлдвэрлэлийн нөөцөд хамаарахгүйг олоорой. 2 оноо

A. Газар Б. Ур чадвар В. Хангамж Г. Капитал

21. Хүний оюуны болон биеийн хүчний чадавх аль үйлдвэрлэлийн нөөцөд хамаарах вэ? 1 оноо

A. Газар Б. Капитал В. Ур чадвар Г. Хөдөлмөр

22. 18 насанд хүрээгүй хүн бүрийг.....гэнэ. 2 оноо

A. Насанд хүрэгсэд Б. Хүүхэд В. Том хүн

23. Хүүхэд үндсэн хэдэн эрхтэй вэ? 2 оноо

A. 4 Б. 6 В. 3 Г. 2

24. Хүмүүс нас, хүйс, арьс үндэс, нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн болон мэндэлснийхээ хувьд эрх тэгш байна. Хүн бүрийн эрхэм зэргийг хүндэтгэн, аливаа байдлаар алагчлах, ялгаварлан гадуурхах ёсгүй. Хүний эрхийн ямар зарчим бэ? 2 оноо

A. Түгээмэл байх зарчим Б. Тэгш байх зарчим В. Харилцан хамааралтай байх зарчим
Г. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим

25. Хүмүүс хоорондын тэгш бус харилцаа үүсэх анхдагч нөхцөл болдог ялгарлыг олоорой. (Хүний нас, хүйс, үндэс угсаа, биеийн хүч зэрэг нь энэ ялгаралд хамаардаг.) 2 оноо

A. Төрөлхийн Б. Төрөлхийн бус

26. Хүний эрхийн талаарх ололт амжилтаа бататгаж, ямагт ахиц дэвшил гаргах нь төрийн ямар үүрэг вэ? 2 оноо

A. Хангах Б. Хамгаалах В. Ахиц дэвшил гаргах Г. Хүндэтгэх

27. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулах нь төрийн ямар үүрэг вэ? 2 оноо

A. Ахиц дэвшил гаргах Б. Хамгаалах В. Хангах Г. Хүндэтгэх

28. Бүх нийтээр даган мөрдөхөөр төрөөс тогтоосон хэм хэмжээний тогтолцоог гэнэ. 2 оноо

A. Эрх зүй Б. Ёс зүй В. Зан заншил Г. Итгэл үнэмшил

29.гэдэг бол үйл ажиллагааны хэд хэдэн чиглэл, асуудлыг шийдэх олон хувилбаруудаас аль оновчтойг нь сонгох үйл явц юм. 2 оноо

A. Сонголт хийх Б. Шийдвэр гаргах В. Шийдвэрлэх асуудлаа олох

30. Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явц хэдэн үе шаттай вэ? 2 оноо

- А. 4 Б. 5 В. 6 Г. 7

31. Гарч буй бодлого, шийдвэрийн агуулга, цар хүрээ, найруулга зэргийг мэргэжлийн ажилтнууд эсвэл, хурлын төлөөлөгчид, Засаг даргын ажлын алба боловсруулдаг. Энэ нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? 2 оноо

- А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Боловсруулах

32. Тухайн бодлого, шийдвэр хаанаас гарахаас шалтгаалж, ИТХ-ын эсвэл ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар, Засаг даргын ажлын албаны хурлаар хэлэлцэх нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? 2 оноо

- А. Хэрэгжүүлэх Б. Хэлэлцэх В. Батлах Г. Үнэлгээ хийх

33. Иргэд өөрийн орон нутгийн баг хорооны ИНХ-д шууд оролцож, ИТХ-ын төлөөлөгчдийг шууд сонгодог. 2 оноо

- А. Тийм Б. Үгүй

34. Харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгчийг олно уу. 2 оноо


- А. ИНТ Б. ИНХ В. Засаг дарга Г. Орон нутгийн зөвлөл

35. Гарсан бодлого шийдвэр хэрхэн хэрэгжиж байгаад мэргэжлийн байгууллага, хүмүүс үнэлгээ хийх нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? 2 оноо

- А. Санаачлах Б. Хэлэлцэх В. Үнэлгээ хийх Г. Батлах

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Задгай даалгавар

36. А. Маслоугийн хүний хэрэгцээний онол 5 шатлалд хуваагддаг. Хамгийн доод шатлалаас дээд шатлалын дагуу гүйцээн бичээрэй. 6 оноо



37. Соёлын ангилалыг гүйцээн бичнэ үү? 6 оноо

С о ё л	[Blank]	
	[Blank]	
	Орон нутгийн соёл	
	[Blank]	
	Нийт хүн төрөлхтний соёл	

38. Дараах эдийн засгийн ойлголтуудыг зөв харгалзуулаарай. 6 оноо

1. Эрэлт	А. Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
2. Нийлүүлэлт	Б. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ.
3. Үнэ	В. Эрэлт нийлүүлэлтийн муруйн огтлолцлын цэгийг хэлнэ.
4. Тэнцвэрт үнэ	Г. Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа төлж буй мөнгөн дүн.

А. 1б 2в 3а 4г Б. 1в 2а 3г 4а В. 1в 2а 3а 4г Г. 1а 2б 3г 4в

39. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргүүдийг зөв харгалзуулаарай. 6 оноо

1. Хамгаалах	А. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулна.
2. Хангах	Б. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх
3. Хүндэтгэх	В. Төрийн зүгээс сургууль, эмнэлэгийг байгуулах зэргээр хүн бүр эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
4. Ахиц дэвшил гаргах	Г. Хүний эрхийн талаарх ололт амжилтаа бататгаж ямагт ахиц дэвшил гаргах

А. 1Б 2В 3А 4Г Б. 1А 2В 3Г 4Б В. 1В 2А 3Г 4Б Г. 1Г 2А 3Б 4В

40. . Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцыг зөв дараалалд байрлуулаарай. .боноо

1.	
2.	
3.	
4.	
5.	
6.	

Батлах, Санаачлах. Хэлэлцэх, Боловсруулах, Үнэлгээ хийх, Хэрэгжүүлэх

VIII АНГИЙН “НИЙГЭМ СУДЛАЛ” ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

2023.05.31

Сурагчийн нэр:

Хугацаа: 80 минут

Хувилбар Б

1. Хоёрдогч бүлэг аль нь вэ? 2 оноо

A. Найз нөхөд Б. Гэр бүл В. Хамаатан садан Г. Дугуйлан

2. Зөрчилдөөнийг эрчимээр нь хэрхэн ангилдаг вэ? 2 оноо

A. Ил болон далд Б. Ширүүн болон алгуур В. Богино болон урт Г. Макро болон микро

3. Зөрчилдөөнийг шалтгаанаас нь хамааруулан 3 ангилдаг. Илүүцийг олно уу? 2 оноо

A. Материаллаг Б. Оюуны В. Нийгмийн Г. Аюулгүй байдлын

4. Хувь хүмүүс өрх гэрүүд хоршин амьдрах шалтгаан нь хоёр үндсэн хэв шинжтэй байдаг. Энэ нь механик эв нэгдэл, “органик нэгдэл” гэж хэн нэрлэсэн бэ? 2оноо

A. Э. Дюркгейм В. Д.Истон С.А.Линкольн D. Адим Смит

5. Зөрчилдөөнийг хэлбэрийн хувьд хэрхэн ангилдаг вэ? 2оноо

A. Ил болон далд Б. Ширүүн болон алгуур В. Богино болон урт Г. Макро ба микро

6. Зөрчилдөөнийг хугацааны хувьд хэрхэн ангилдаг вэ? 2 оноо

A. Ил болон далд Б. Ширүүн болон алгуур В. Богино болон урт Г. Макро болон микро

7. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хэдэн алхам байдаг вэ? 2оноо

A. 4 Б. 3 В. 2 Г. 5

8. Хувь хүний соёл хэдэн бүрдэл хэсэгтэй вэ? 2 оноо

A. 6 Б. 5 В. 4 Г. 3

9. Хувь хүний болон нийгмийн бүлгүүдийн соёлын сонголтын ялгаатай байдлыг илэрхийлдэг ойлголт аль нь вэ? 2оноо

A. Соёлын олон янз байдал Б. Соёлын үнэт зүйл В. Соёлын өв

10. . Соёл нь биет болон биет бус хоёр хэлбэртэй. Биет бус соёлд хамаарахгүйг олоорой 2оноо.

A. Археологийн олдвор Б. Зан заншил В. Мэдлэг Г. Боловсрол

11. . Соёлын материаллаг талд хэт их ач холбогдол өгч, хэрэглээг шударга үнэн, хүнлэг сэтгэлээс эрхэмд үзэх явдал даамжирснаас болж нийгэмд үүсдэг сөрөг үр дагавар аль нь вэ? 2 оноо

A. Соёлын нэвчилт Б. Соёлын үнэт зүйл В. Соёлын бүтэц Г. Соёлын хожимдол

12. Соёл нь биет болон биет бус хоёр хэлбэртэй. Биет бус соёлд хамаарахыг олоорой.
2 оноо

A. Машин техник Б. Барилга В. Домог үлгэр Г. Хөшөө дурсгал

13.Материаллаг соёл аль нь вэ? 2 оноо

A. Археологийн олдвор Б. Уртын дуу В. Баяр наадам Г. Дээрх бүгд

14. Оюуны соёлын жишээнд аль хамаарах вэ? 2оноо

A. Олдвор Б. Шинжлэх ухаан В. Барилга Г. Хөшөө дурсгал

15. Хүмүүсийн хэрэгцээний хангамжийг эдийн засагт.....гэж нэрлэдэг. 2 оноо

A. Хэрэглэгч Б. Хэрэглээ В. Баялаг Г. Эрэлт

16. Хүмүүсийн хэрэгцээнд зориулагдсан биет ба биет бус зүйлсийг..... гэнэ. 2 оноо

A. Хэрэглээ Б. Нөөц В. Баялаг Г. Үйлдвэрлэл

17. Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээггэнэ. 2 оноо

A. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Үнэ

18. Орон нутгийн эдийн засгийн салбаруудад үл хамаарахыг олоорой.2 оноо

A. Үйлдвэрлэл Б. Худалдаа, үйлчилгээ В. Хөдөө аж ахуй Г. Соёлын төв

19. Машин, тоног төхөөрөмж, барилга, зам гүүр, түүхий эд, материал, эд хогшил, мөнгө эдгээр нь аль үйлдвэрлэлийн нөөцөд хамаарах вэ? 2 оноо

A. Газар Б. Ур чадвар В. Капитал Г. Хөдөлмөр

20. Мөнгөтэй түүнийгээ зарцуулах сонирхолтой худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдагчид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэлийг гэнэ. Цэгийн оронд тохирохыг олно уу.2 оноо

A. Эрэлт Б. Нийлүүлэлт В. Зах зээл Г. Тэнцвэрт үнэ

21. Байгууллагын хэлбэрийг хэд ангилдаг вэ? 2 оноо

A. 4 Б. 3 В. 2 Г. 5

22. Монгол улс хүүхдийн эрхийн тухай хуулийг хэдэн онд шинэчлэн баталсан бэ? 2 оноо

A. 2018он Б. 2016он В. 2019он Г. 2017он

23. Болд хүүхдийн мөнгөө цуглуулж гар утас худалдан авав. Тохирох эрхийг сонгоно уу?

2 оноо

А. Өмчлөх Б. Хамгаалуулах В. Оюуны бүтээлээ өмчлөх

24. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвөл сэргээн эдлүүлэх нь төрийн хүлээх аль үүрэг вэ? 2 оноо

А. Хангах Б. Хүндэтгэх В. Хамгаалах Г. Ахиц дэвшил гаргах

25. Хүний эрх нь төрөөс олгож буй “хишиг” биш, харин хүн төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. Иймд хүний эрх нь хүн бүрийн амьдралын салшгүй хэсэг байна. Хүний эрхийн ямар зарчим бэ? 2 оноо

А. Хуваагдашгүй байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Тэгш байх зарчим Г. Хариуцлага хүлээх зарчим

26. Хүний эрх нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс тул дэлхийн бүх улс орон, бүс нутагт хүлээн зөвшөөрч, нэг мөр ойлгож хэрэгжүүлнэ. Хүний эрхийн ямар зарчим бэ? 2 оноо

А. Тэгш байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Түгээмэл байх зарчим Г. Хариуцлага хүлээх зарчим

27. Нэгэн хорооны нутаг дэвсгэрт нийтэд зориулсан хогийн сав хангалтгүй учир орчны бохирдол улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь иргэдийн ямар эрх зөрчигдөж байна вэ? 2 оноо

А. Амьд явах эрх Б. Халдашгүй байх эрх В. Эрүүл байх эрх Г. Эвлэлдэн нэгдэх эрх

28. Хүний нэг эрх зөрчигдөхөд бусад эрх мөн зөрчигдөх үндэс болно. Иймд хүний эрхийн бүхий л асуудлыг өөр хооронд нь харилцан хамааралтай, цогц байдлаар шийдвэрлэх ёстой. Хүний эрхийн ямар зарчим бэ? 2 оноо

А. Харилцан хамааралтай байх зарчим Б. Салшгүй байх зарчим В. Хариуцлага хүлээх зарчим зарчим Г. Тэгш байх зарчим

29. Хүүхдийн оролцоонд баримтлах хэдэн зарчим байдаг вэ? 2 оноо

А. 3 Б. 2 В. 4 Г. 5

30. Сурагчдын өөрөө удирдах байгууллага бол.....байгууллага юм. Цэгийн оронд тохирохыг үгийг нөхнө үү? 2 оноо

А. Удирдлагын Б. Суралцагчдын В. Сургуулийн

31. Орон нутгийн түвшинд бодлого шийдвэр аль түвшинд гарахаас хамаарч хурлын төлөөлөгч, намын бүлэг, засаг дарга, түүний ажлын алба санаачилдаг энэ нь орон нутгийн бодлого, шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? 2 оноо

А. Санаачлах Б. Хэлэлцэх В. Хэрэгжүүлэх Г. Үнэлэх

32. Зөв харгалзуулна уу? 2 оноо

1. Эрх эдлэгч А. Бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.
2. Үүрэг хүлээгч Б. Хүний эрх зөрчигчдөд хариуцлага оногдуулна.
 А. 1А 2Б Б. 1Б 2А

33. Орон нутгийн удирдлагаас гарах бодлого, шийдвэрийг ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчид тогтоол гарган, бүх шатны Засаг дарга нар захирамж, тушаал гарган батлах нь орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын ямар үе шат вэ? 2 оноо

- А. Үнэлгээ хийх Б. Хэлэлцэх В. Санаачлах Г. Батлах

34. Тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцох байдал, идэвхийг хэрхэн нэрлэдэг вэ? 2 оноо

- А. Мэдээлэл Б. Оролцоо В. Шийдвэр Г. Бодлого

35. Баг хорооны засаг даргыг.....нэг удаа сонгодог. Аль тохирохыг нөхөж бичнэ үү? 2 оноо

- А. 3-н жилд Б. 4-н жилд В. 5-н жилд Г. 6-н жилд

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Задгай даалгавар


36. Зөрчилдөөнийг шийдвэрлэх алхамыг зөв дараалалд байрлуулна уу? 6 оноо

3



Эвлэрүүлэн зуучлагч туслах, Зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлсэн орчин, Талууд ойлголцож шийдэлд хүрэх

37. Орон нутгийнхаа соёлд хувь нэмрээ оруулж буй байгууллагуудыг нэрлэнэ үү? 6 оноо



38. . Зөв харгалзуулаарай. 6 оноо

1. Төрийн байгууллага	А. Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг ашиг олох зорилготой байгууллага
2. Төрийн бус байгууллага	Б. Төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллага
3. Аж ахуйн нэгж	В. Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдэн үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус байгууллага

А. 1а 2в 3б Б. 1в 2б 3а В. 1б 2а 3в Г. 1б 2в 3а

39. Хүмүүс хоорондын ялгаралыг тэдний нийгмийн шинж чанараас хамааруулан хоёр ангилна. Тус бүр 3 жишээ бичээрэй. 6 оноо

Төрөлхийн ялгарал

- 1.....
- 2.....
- 3.....

Төрөлхийн бус ялгарал

- 1.....
- 2.....
- 3.....

40. Орон нутагт шийдвэр гаргах үйл явцын зураглалыг гүйцээн бичнэ үү? 6 оноо

